

**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ**

Дугаар 01/2026

2026-04-09

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны үр дүн,
2026 оны үндсэн зорилтын тухай

“Улаанбаатар хивс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан болон 2026 оны үндсэн зорилт, үзүүлэлтүүдийн тухай хэлэлцсэн, хувьцаа эзэмшигчдийн санал, шүүмжлэл болон тооллогын комиссын хуралтын үр дүнг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнг тайлангаар хүлээн зөвшөөрсүгэй.

2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2026 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг дараахь байдлаар тогтоон баталсугай.

| | |
|----------------------------|----------------|
| - Үйлдвэрлэл | 55 000 м2 |
| - Борлуулалт | 8 500 сая. төг |
| - Хөрөнгө оруулалт | 300 сая. төг |
| - Цэвэр ашиг | 1 210 сая. төг |
| - Үйлдвэрлэлийн нэгж өртөг | 110 000 төг/м2 |

3. Компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны чиглэлээр тавьж буй үндсэн зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд 2026 онд компанийн техник, технологи, эдийн засгийн нөөц бололцоог илүү үр ашигтайгаар удирдан зохион байгуулж ажиллахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ДАРГА



Ё.ЭНХТӨР